



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/685,

Улаанбаатар хот

“Баянгол дүүргийн 338 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 522,000.00 (таван зуун хорин хоёр мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянгол дүүргийн 87 дугаар цэцэрлэг, 1,710,000.00 (нэг сая долоон зуун арван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянгол дүүргийн 278 дугаар цэцэрлэгийн баланст тус тус шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн 338 дугаар цэцэрлэг (У.Оюуннаран)-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 87 дугаар цэцэрлэг (Х.Пүрэвсүрэн), Баянгол дүүргийн 278 дугаар цэцэрлэг (Г.Наранцэцэг)-т тус тус даалгасугай

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В. Оюумаа

В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10-р дугаар сарын 11-ны өдрийн А/68-дугаар тушаалын хавсралт

Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 338 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ /2024.11.30/	Хуримтлагдсан элэгдэл /2024.11.30/	Үлдэгдэл өртөг /2024.11.30/	Шилжүүлэн авах байгууллага
1	1-р хоолны тогоо /100 литрийн/	Чиглэл	2024.08.31	ш	1	522,000.00	522,000.00	0.00	522,000.00	Баянгол дүүргийн 87 дугаар цэцэрлэг
2	Хөлдөөгч	Shun kang da	2024.08.31	ш	1	1,710,000.00	1,710,000.00	0.00	1,710,000.00	Баянгол дүүргийн 278 дугаар цэцэрлэг
Тоног төхөөрөмжийн дүн							2,232,000.00	-	2,232,000.00	